

ӨВӨР МОНГОЛ БОЛОН МОНГОЛ УЛСЫН МАЛ АЖ АХУЙН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ БОЛОМЖИЙН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ

Н.Улаан-Од *

Өвөр Монголын өөртөө засах орон (ӨМӨЗО) нь 8600 гаруй га бэлчээртэй, мал аж ахуй бол манай орны улс ардын аж ахуйн суурь аж үйлдвэр болох бөгөөд уламжлалт давуулаг салбар болох юм. Монгол улс нь 156.41 км нутаг дэвсгэртэй бөгөөд 124 сая га тал хээрийн бэлчээртэй. Мал аж ахуй нь Монгол улсын улс ардын аж ахуйн хамаг чухал салбарын нэг болно. Иймээс Өвөр Монгол болон Монгол улс нь мал аж ахуйн салбарт харилцан нөхвөрлөж, хамтран ажиллах маш олон сайн сайхан нөхцөл бололцоотой болж байна.

2005 оны 12-р сарын 15-ны өдөр ӨМӨЗО-ны дарга Ян Жингийн урилгаар Монгол улсын Хүнс, хөдөө аж ахуйн яамны сайд асан Тэрбишдагва манай оронд найрсаг айлчлалт хийж, хоёр тал мал аж ахуйн салбарт нягт хамтран ажиллах тухай зарим бичиг баримтад гарын үсэг зурсан юм. Хоёр тал нь хоёр орны аж ахуйн хөгжилтийг түргэтгэж, ард түмний амьдралын түвшнийг үтэр түргэн дээшлүүлэхэд, мал аж ахуйн салбар дахь хамтын ажиллагааг улам нэг алхам эрчимжүүлэх явдал нь маш чухал ач холбогдолтой гэж үзсэн байна.

2008 оны 3 сарын хорьдоор Монгол улсын Гадаад хэргийн сайд С.Оюун манай улсад албан ёсны айлчлал хийх үеэр Өвөр Монголд зочилж, мал аж ахуйн салбарт хоёр тал хамтран ажиллах шинэ боломжийг биечлэн судалж, Хөх хотын хэд хэдэн томоохон сүүний үйлдвэрийг сонирхсон юм.

Өвөр Монгол болон Монгол улс хоорондоо 3193 км урт хилийн шугамтай бөгөөд улсын дэсийн 5 боомт, орны дэсийн 5 боомт нээн ажиллуулж байна. Энэ нь хоёр талын мал аж ахуйн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд онцгой сайн нөхцөл бололцоог бүрэлдүүлж өгч байх юм.

Нэг. Мал аж ахуйн салбарт хоёр тал хамтран ажиллаж ирсэн өнгөрсөн ба одоохи байдал

Хятад, Монголын хоёр улсын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагаа нь 20 дугаар зууны наяд оны эхэн үеэс сэргэснээс нааш маш түргэн хөгжиж ирсэн юм. Үүнд хоёр талын мал аж ахуйн салбарын хамтын ажиллагаа нэлээд онцгой байрыг эзэлдэг. Тухайлбал сүүлийн жилүүдэд хоёр талын Засгийн газрын дээд хэмжээний албан хаагчид харилцан айлчилснаас гадна, тухайлсан ажил мэргэжлийн, эрдэм шинжилгээний, сургалт сурталчилгааны байгууллагууд болон аж ахуйн нэгжүүд хоорондоо олон хэлбэрээр мал аж ахуйн талаарх

* Өвөр Монголын их сургуулийн дэд профессор, докдорант

хамтын ажиллагаагаа өрнүүлж, харилцан бодит байдалтай биечлэн танилцан, туршлага солилцож ирсэн түүхтэй юм. Үүнд голдуу:

1. Бэлчээрийн ургац, усны нөөц, хөрс болон бэлчээр ашиглалтын байдал;
2. Бие биеийнхээ оршин сууж байгаа газрын нүүдлийн ба суурин мал аж ахуйн ахуй байдал, зан заншил, аж төрх арга барил;
3. Мал малжих арга барил, үрийн мал сонгон бойжуулах, өвчин хижгээс урьдчилан сэрхийлэх арга хэмжээ, малын бүтээдэхүүний зах зээл дэх үнэ ханш;
4. Малын бэлчээрийг хуваан даачилж байх алдаа оноо зэрэг олон агуулгаар хамтран ажиллаж ирсэн юм.

Сүүлийн жилээс хоёр талд мал аж ахуйн салбарт нягт хамтран ажиллах маш их өргөн боломжууд нээгдэж байна. Үүнд: хоёр талын орон нутгийн аймаг сумны албан байгууллага, хувь хүн, арилжаа наймаа хийгчид харилцан айлчилж, оторлон малжих, хашаалан тэжээх арга туршлагаа дүгнэн солилцох, малын үр өгөөжийг дээшлүүлэх, сайн үүлдрийн үрийн мал солилцох, малын удмын сангийг хамгаалах зэрэг үйл ажиллагаа хамрагдаж байна.

Хоёр. Хамтын ажиллагааг хөгжүүлэхэд нөлөөлөх хүчин зүйл болон хэтийн төлөв

ӨМӨЗО болон Монгол улсын мал аж ахуйн салбарт хамтран ажиллах чухал чанарын тухай танилтаа нэгтгэн дээшлүүлэх үүднээс хамтын ажиллагааг харшлах зүйл бүрийн хүчин зүйлд бодит задлалт хийх нь зүйтэй юм.

1. Эерэг ба сөрөг хүчин зүйлүүд:

1. Хятад, Монгол хоёр улс нь цөм ДХБ-ын гишүүн учраас түүний журам горимын дагуу харилцан өөр өөрийн улсынхаа зах зээлийг чөлөөтэй нээж өгөх үүрэгтэй.

2. Өвөр Монгол болон Монгол улс нь уул усаараа залгалдаж байгаа хөрш бөгөөд байгалийн нөхцөл байдлын талаар адил буюу ойролцоо, мал аж ахуйг эзэгнэж ирсэн түүх болон арга барил нь нэлээд адилхан байдаг.

3. Сүүлийн жилээс Өвөр Монгол болон Монгол улсын хоорондох мал аж ахуйн хамтын ажиллагаа харьцангуй бага байгаа боловч хоёр тал нь өнгөрсөнд уламжлалт мал аж ахуйг дагнан аж төрж ирсэн тул одооны нөхцөлд гэсэн ч бие биеийн байдлыг нэлээд сайн мэддэг.

4. Хоёр талын уламжлалт мал аж ахуйг хөгжүүлж ирсэн арга барил ерөнхийдөө адилавар, байгалийн нөхцөл бололцоо нэлээд ойролцоо байдаг. Иймээс мал аж ахуйн салбарт бие биеэ нөхөх тодорхой зүйл цөөн тул харилцан сонирхох сонирхол дутмаг байдаг.

5. Өвөр Монголд нүүдлийн мал аж ахуй ерөнхийдөө устаж, суурин мал аж ахуй буй болж, оторлохоо зогсож хашаалан малжих арга барилыг авч таван хошуу малын бүтэцдээ маш их өөрчлөлт оруулж, зөвхөн сүүний чиглэлээр хар алаг үнээг түлхүү хөгжүүлж байгаа явдал нь хоёр талын хамтын ажиллагаанд шинэ агуулгыг нэмсэн байна.

6. Монгол улсын мал аж ахуйн салбарын үндсэн бүтээн байгуулалт сул, төрөөс нь мал аж ахуйн салбарт өгч байгаа хөрөнгө мөнгө нь бага зэргээс

шалтгаалж иргэд нь гадагш гарч хамтран ажиллах хүчтэй үйл ажиллагаа явуулах цар хүрээ нь хязгаарлагдмал байдаг.

7. Сүүлийн хоёр жилээс шүлхий өвчнөөс шалтгаалж, манай тал малын гаралттай бүтээгдэхүүнийг оруулж гаргахыг түр хороглож байх тул хоёр талын хамтын ажиллагаа зөвхөн харилцан туршлага солилцох, нутаг бэлчээрийн ашиглалт, хижгээс сэрхийлэх, малын эм бэлдмэл худалдан авах болон нүүдлийн мал аж ахуй ба суурин мал аж ахуйн талаар судалгаа хийх зэрэг явцуу хүрээнд явагдаж байна.

II. Хамтын ажиллагааны хэтийн төлөв

Дээрх байдлаас үзэхэд, хоёр талаараа ашиггүй талаа тэвчиж, ашигтай талаа бадруулах л юм бол Өвөр Монгол болон Монгол улс нь мал аж ахуйн салбарт харилцан хамтран ажиллах нэлээд олон нөхцөл бололцоотой юм. Тухайлбал:

1. Өвөр Монгол нь сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар нэлээд амжилт олж, бүх орноор барахгүй бүх улсын сүүний хэрэгцээний дийлэнх хэсгийг хангах хүчин чадалтай болсон тул сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулах талаар Монголын талтай хамтран ажиллах нэлээд туршлага хурамдуулсан юм.

2. Өвөр Монголд адууны аж ахуй сүйрлийн байдалд орсон энэ үед, Монголын гүүний сүү үйлдвэрлэх, морин спорт эрхлэх, аялал жуулчлалд ашиглах, адууны махыг хэрэглэж байгаа арга туршлагаас суралцах боломж нэлээд гарч байна.

3. Өвөр Монголд хэдийгээр бэлчээрийг хуваан даачлан эзэгнэж байгаа боловч Монголын бэлчээр ашиглах талаарх уламжлалт технологи болон туршлагыг сурч судалж болох юм. Мөн цөлжилтийг зогсоох болон экологийн бүтээн байгуулалтын талаар хоёр тал нягт хамтран ажиллаж болно.

4. Өвөр Монгол болон Монгол улс нь НҮБ-ын “Олон улсын нутаг бэлчээрийг зөв зохистой ашиглах” төсөлд хамтран оролцож, мал аж ахуйн салбарт харилцан судалгаа шинжилгээ хийж болох боломж бүрэлдэж байхыг саяхан Батхишиг тэргүүтэй Монгол улсын нутаг бэлчээрийн ашиглалтын судалгааны группын ажлын үр дүнгээс санаа авч болох юм.

5. Хоёр талын мал аж ахуйн салбарын судалгааны байгууллага, их дээд сургуулийн эрдэм шинжилгээний байгууллага болон Олон улсын төслийн байгууллагуудын хоорондох уялдаа холбоог нягтруулан сайжруулж, хамтарсан судалгаа шинжилгээ хийх ажлыг зохион байгуулж болох нөхцлүүд бүрэлдсэн юм.

6. Өвөр Монголын орчин үеийн том сүүний үйлдвэрүүд нь Монголд сүүн бүтээгдэхүүн борлуулах цэг буй болгох, сүүний жижиг үйлдвэр байгуулах, сүүний үнээний ферм эрхлэхээр дамжин олон улсын зах зээлд сүүн бүтээгдэхүүн борлуулах гарц хайж болох юм.

7. Хоёр тал нь газар зүйн давуулаг талаа ашиглан солилцож болох малын ашиг шимийн бүтээгдэхүүн ба мал аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгслийн хүрээнд хамтын ажиллагааг үргэлжлүүлэн өргөтгөж болох орон зай их байна.

III. Авах арга хэмжээ ба хэдэн санал

1. Өвөр Монгол болон Монгол улсын хоорондох мал аж ахуйн салбарын хамтын ажиллагааг тус орныхон улс ардын аж ахуйгаа хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний хүрээнд авч үзэх бөгөөд алхам дараатай хэрэгжүүлэх хэрэгтэй.

2. Хоёр талын мал аж ахуйн салбар дахь хамтын ажиллагааны зарчим бол ДХБ-ын зарчим байх ёстой. Энэ нь харилцан хөнгөлөлттэй, үл гадуурхах, өөрийн иргэний хөнгөлөлт үзүүлэх, тоо хэмжээний хязгаарлалыг арилгах, зах зээлдээ оролцуулах зэрэг зарчмыг баримтлах хэрэгтэй.

3. 2001 оны 6 сард баталсан “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын бодлого болон манай улсын баруун бүс нутгийг ихээр хөгжүүлэх бодлого хоёрын гол үзэл санаа, чиглэл зорилго нь олон талаар нийцэж байгаа ба тэдгээрийг хэрэгжүүлэх зорилт, арга зам, нөхцөл бололцооны хувьд ихээхэн ойр дөт, адил төсөөтэй юм. Иймээс эдгээр төрийн бодлогын хэрэгжүүлэлтийн явц дахь давуу талыг бүрэн төгөлдөр ашиглах хэрэгтэй.

4. Өвөр Монгол болон Монгол улсын хил залгаа аймаг хошууны эдийн засаг, байгалийн нөөц баялаг, уур амьсгал, газар нутгийн шинж байдал, экологи болон ерөнхий хөгжлийн түвшний хувьд адил төсөөтэй зүйл олон бий. Иймд тэдгээрийг хөгжүүлэхэд хоёр талын цогц бодлогын зорилтыг хэрэгжүүлэх явдлыг уялдуулах, харилцан шүтэлцээтэйгээр авч үзэх шаардлага, бодит хүчин зүйл урган гарч байх тул мал аж ахуйн салбарт хоёр тал нягт хамтран ажиллах өргөн аз завшаан бүрэлдэж байх явдлыг анхаарах хэрэгтэй.

5. Өвөр Монголд хашаалан малжих арга барицыг авч хэрэглээд нэлээд хэдэн жил болж байгаа байдлаас Монголын тал туршлага сургамж солилцож, өөрийнхөө бодит байдалдаа тохируулан мал аж ахуйн салбараа хөгжүүлбэл зохино. Нэн ялангуяа нүүдэл малжлын соёл, түүний доторх үндэстний үзэл ухамсрын хэлбэр, үндэстний зан дадал, ёс мориол, шашин суртахуун, итгэл бишрэл, орчин ахуй, байгаль экологио хамгаалах үнэт нандин зүйлийг хадгалан хамгаалах явдлыг маш анхаарах хэрэгтэй.

Ном зүй

1. Хөх хотод болсон “НҮБ-ын бэлчээр ашиглалтын сектарыг тогтвортой хөгжлийн төсөл”-ийн хамтарсан хурал дээр Монголын талын ахлагч Батхишигийн хэлсэн үг, 2006.12.7,
2. Хөх хотод болсон “НҮБ-ын бэлчээр ашиглалтын секторыг тогтвортой хөгжлийн төсөл”-ийн хамтарсан хурал дээр Өвөр Монголын их сургуулийн профессор Энхээгийн хэлсэн үг, 2006.12.7
3. Хөх хотод болсон “НҮБ-ын бэлчээр ашиглалтын сектарыг тогтвортой хөгжлийн төсөл”-ийн хамтарсан хурал дээр Өвөр Монголын ШУА-ын профессор Эрдэнэбөхийн хэлсэн үг, 2006.12.7
4. Өвөр Монголын Дархан муу мянган хошууны Мал аж ахуйн товчооны мэргэжилтэн Цэнгэлийн хэлсэн үг, Бат хаалга балгас, 2006.12.8
5. Өвөр Монголын Дархан муу мянган хошууны Шинэ булаг гацааны дарга Эрдэнэцогтын хэлсэн үг, Шинэ булаг гацаа, 2006.12. 9